



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Хяналтын хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.3."а" дахь дэд заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар батлагдсан "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хэрэгжилтэд хяналт тавих, төслийн хэрэгжилттэй холбоотой гомдол, саналыг хэлэлцэх, нөхөх олговрын хэмжээг тогтоох зорилгоор үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хяналтын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Хяналтын хорооны дарга:

Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч

Гишүүд:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

-Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дарга;

-Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны орлогч дарга;

-Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн дарга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Барилга, орон сууцны бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;

-Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагч;

-Төсөл хэрэгжүүлэх хэсэгчилсэн талбайн иргэдийн төлөөлөл (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга:


Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

111020000581

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган Нийслэлийн Засаг даргад улирал тутам тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатарт даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан "Хяналтын хороог шинэчлэн байгуулах тухай" Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/69 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Д.СУМЪЯАБАЗАР